



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2019 оны 09 сарын 10 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн байгууллагуудын төсөв,
санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлж,
Төсвийн тухай хуулийг мөрдлөг болгон өр төлбөргүй ажиллах тухай

Төсвийн тухай хууль, Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг баримтлан Эрүүл мэндийн сайдын багцын байгууллагуудын 2019 оны төсвийн сахилга хариуцлагыг дээшлүүлж, төсвийг үр ашигтай зарцуулан өр төлбөргүй ажиллах зорилгоор аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт ДААЛГАХ нь:

1. Батлагдсан төсвийн хүрээнд орон тоо, цалингийн сан хэтрүүлэхгүй ажиллах
2. Цалин, нэмэгдэл урамшууллыг тооцож олгохдоо Засгийн газрын тогтоолоор батлагдсан албан тушаалын цалингийн жишгийг баримтлан тогтоож, тогтоол шийдвэрээс бусад нэмэгдэл урамшил олгохгүй байх
3. Сар бүрийн төсвийн гүйцэтгэл болон өр, авлагын мэдээ мөн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж ирүүлж хэвших
4. Эрүүл мэндийн байгууллагуудын 2019 оны эхний 7 сарын байдлаар бий болсон үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.3 дах заалт, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын дагуу дараах байдлаар эрэмбэлэн зарцуулах. Үүнд:
 1. Эрүүл мэндийн сайдын багцын хэмжээнд хагас жилийн байдлаар төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр 1,1 тэрбум төгрөгийн өглөг үүссэн тул өр төлбөртэй байгууллагууд зөвхөн өр барагдуулах зорилгоор зарцуулах

080039

2. Төсвийн тухай хуулийг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулж өр төлбөр үүсгэлгүй ажиллаж байгаа байгууллагууд нэмэлт орлогыг "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын дагуу зарцуулах
3. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг үндэслэн өр төлбөртэй байгууллагуудын давсан орлогыг эдийн засгийн ангиллаар хавсралтаар хүргүүлж байна.
4. Төсвийн хуваарийг хавсралтаар хүргүүлэв.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ